

ХАР ТАМХИНЫ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХОРИГДЛУУДАЙ АЖИЛЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ



Г.ТАМИР

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа
421 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа

Товч агуулга: Монгол Улсад сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт эрчимтэй нэмэгдэж аюулын харанга дэлдэж байна. Цаашдаа ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх төлөвтэй. Хорих байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж хорих ял эдлэгчдийн тоо өссөөр байна. Одоогоор хорих ял эдлэгчдийн дотор мансууруулах бодист донтогч байхгүй боловч ирээдүйд ийм этгээд ял эдлэх нь тодорхой. Иймд хар тамхинд донтогч, идэвхтэй хэрэглэгч хоригдлуудтай хэрхэн ажиллах тухай бэлтгэлийг нэн яаралтай хангах талаар санал дүгнэлт дэвшүүлсэн.

Abstract: In recent years, the prevalence of crimes related to the illegal flow of drugs and controlled substances has progressively increased and is becoming a threat in Mongolia. In the future, this kind of crime is expected to grow and the number of inmates who commit such crimes is increasing. Although currently there are no inmates who are addicted to drugs, in the future, it is expected that a subject who abuses drugs might be sentenced to serve in prison. Thus, we have urgently put forth recommendations regarding preparation for working with inmates who are addicted to and actively abuse drugs.

Түлхүүр үг: Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хар тамхи, хорих ял эдлүүлэх ажиллагаа, албадан эмчилгээ, сургалт, нийгэмшүүлэх ажил, сэтгэл заслын үйлчилгээ

Key words: narcotics, substances that affect mental health, drugs, imprisonment operations, forced treatment, training, rehabilitation work, mental treatment services.

Сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралт

эрчимтэй нэмэгдэж, энэ нь манай улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал: 1986-2012 он хүртэл 26 жилийн хугацаанд дээрх төрлийн 67 гэмт хэрэгт 157 хүн ял шийтгүүлсэн байдаг. Гэтэл сүүлийн 5 жилд энэ төрлийн 553 гэмт хэрэг бүртгэгдэж олон тооны этгээдүүд шалгагджээ ¹ /график-1/. Монгол Улсын шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан²-аас үзвэл 2016 онд 74 хэрэгт 138 хүн, 2017 онд 85 хэрэгт 85 хүн, 2018 онд 128 хэрэгт 113 хүн ял шийтгүүлсэн байна. /график-2/

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл: 2016 онд мансуурсан 65, согтуугаар 5520, 2017 онд мансуурсан 92, согтуугаар 4012, 2018 онд мансуурсан 176, согтуугаар 3286, 2019 оны эхний 6 сарын байдлаар мансуурсан 110, согтуугаар 1887 гэмт хэрэг тус тус үйлдэгдсэн тухай мэдээ байна. /график-3/

Мөн дээрх төрлийн гэмт хэрэгт 2015 оны жилийн эцсийн байдлаар 18, 2016 онд 52, 2017 онд 32, 2018 онд 65, 2019 оны 7 сарын байдлаар 91 хүн хорих ял эдэлж байна³. /график-4/ Одоо ял эдэлж 91 хүний 67,3 хувь нь анх удаа, 32,7 хувь нь энэ төрлийн гэмт хэргийг давтан үйлдэгч байна. Үүнээс гадна тухайн гэмт хэрэгт шалгагдан цагдан хоригдож буй 84 хоригдогч өнөөдрийн байдлаар байна. Тэдний олонх буюу 94 хувь нь 19-40 насны буюу залуучууд байна. /график-5/

Гадаад улсад 2006 оноос 2015 оны хооронд манай улсын 126 иргэн хар тамхитай холбоотой гэмт хэрэгт холбогдсон бөгөөд үүнээс тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хилээр нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан 1 иргэн тус тус тухайн орны шүүхээс ял шийтгэгдсэн бол 2016 онд 18 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг⁴.

¹ <http://police.gov.mn/home> ЦЕГ-ын цахим мэдээлэл

² Монгол Улсын 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. www.judinstute.mn

³ ШШГЕГ-ын хорих ял эдлүүлэх албаны 2019 оны 07-р сарын статистик мэдээ

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн судалгаагаар⁵ сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэгч болон түүнд донтогчийн тоо өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Дээрх тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл манай улсад мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралт, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл /цаашид мансууруулах бодис гэх/ хэрэглэгчийн тоо цаашид тогтвортой өсөхөөр байна.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хэрэглэгчийн тоо өсөх болсон шалтгааныг улс орны гадаад дотоод олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал: Хөрш хоёр улс мансууруулах бодисын хууль бус эргэлт, хэрэглээгээр өндөрт тооцогддог, иргэдийн улс хооронд харилцан зорчих явдал, арилжаа худалдаа, мэдээлэл солилцоо улам бүр өссөн зэрэг даяаршлын болон иргэдийн ухамсар, нийгэм хүн ам зүйн олон хүчин зүйлийг дурдаж болно.

Сүүлийн жилүүдэд амфетамин, метамфетаминь төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон.⁶

Өнөөдрийн байдлаар мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж буй нийт хоригдлын 70 гаруй хувь нь мансууруулах бодисыг сонирхон хэрэглэгч байна. Нийт хорих ял эдлэгчдийн дунд хийсэн судалгаагаар мансууруулах бодис идэвхтэй хэрэглэгч буюу донтогч одоогоор байхгүй байна.

ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан хөдөлмөр хийлгэх газарт захиргааны журмаар албадан эмчлүүлсэн мансуурах донтой этгээд одоогоор байхгүй. Гэвч мансууруулах бодист хэт хамаарал бүхий /донтогч/ хоригдол байхгүй гээд тайвширч болохгүй. Өөрөөр хэлбэл мансуурах бодист хэт хамаарал бүхий хоригдлуудтай хэрхэн ажиллах, тэднийг хэрхэн эмчилж нийгэмшүүлэх, хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хорих ангид мансууруулах бодис нэвтрэхээс яаж урьдчилан сэргийлэх, мансууруулах бодисыг таньж илрүүлэх, түүнд зориулсан техник хэрэгсэл

⁵ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны статистик мэдээ, СЭМҮТөв

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралт

ашиглах ур чадварыг алба хаагчиддаа эзэмшүүлэх, мансуурсан хоригдолтой хэрхэн ажиллах зэрэг тулгамдсан олон асуудалд одооноос эхлэн бэлтгэх шаардлагатай байна. Түүнчлэн мансуурах донтой этгээдэд үзүүлэх сэтгэл зүйн болон эмнэлгийн тусгайлсан үйлчилгээний арга технологийг хорих байгууллагад нэвтрүүлж хүний нөөцийг чадавхижуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоод гадаадын бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

2017 онд Монгол Улсын засгийн газраас Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүнээс үүдэх гэмт явдалтай хийх тэмцэлд чухал нөлөөтэй арга хэмжээ болсон. Уг хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 1-р үе шатанд /2017-2019 он/ мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ажлын шинэ арга замыг тодорхойлох; мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг иргэдэд тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулах бол 2-р шатанд /2019-2021 он/ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай холбоо, харилцаа, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хангах; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын болон албадан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний төвийг байгуулах гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн гол эх сурвалж болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлд "...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос тусад нь ял эдлүүлнэ гэж⁷ заасан. Гэвч хуулийн энэхүү зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэгт хорих ял эдэлж буй хоригдлуудыг хоорондоо огт харьцахгүй байхаар тус тусдаа ял эдлүүлэх орчин нөхцөлийг хараахан бүрдүүлж чадаагүй байна. Харин хорих байгууллагын зүгээс мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлж хорих ял эдэлж буй этгээдийн сөрөг нөлөөллөөс бусад хоригдлыг хамгаалахад ихээхэн анхаарч ирсэн.

⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 2017. №24

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хөтөлбөрт үндэслэн мансууруулах бодист хамаарал бүхий хоригдлуудын зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн “Сэтгэл хөдлөлөө хянах нь”, “Гэр бүлийн харилцаа хандлага”, “Зан төлөв, түүний онцлог”, “Донтолт ба нойрны хямрал, “Уур бухимдалаа зохицуулах нь” зэрэг төрөл бүрийн сургалтуудыг төрийн болон төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн.

Түүнчлэн бясалгалын сургалтад энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлуудыг хамруулсан зохих үр дүнгээ өгдөг.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудыг албадан сургалтад хамруулах тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд⁸ заасан боловч уг сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын гарын авлага, сургалт зохион байгуулах хүний нөөц, хөрөнгө мөнгөний асуудал одоогоор нэг мөр шийдвэрлэгдээгүй.

Нөгөө талаас мансуурах донтой этгээдтэй хэрхэн ажиллах, тэдгээрийг эмчлэх, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах, хорт зуршлаас нь салгах чиглэлээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон гадаад дотоодын бусад байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг ихээхэн чухалчилж хүний нөөцөө чадавхижуулахад анхааран ажиллаж байна.

Монгол Улсын эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зөвхөн сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй эсхүл ял эдлэх боломжгүй болсон хүмүүст оногдуулахаар заасан. Харин мансуурах донтой этгээдийг хорих ял эдлэх явцад нь албадан эмчлэх асуудал эрх зүйн зохицуулалтын хувьд хийдэлтэй байна.

Энэхүү илтгэл мэдээллийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мансуурах донтой, хар тамхинд хамаарал бүхий хоригдолд үзүүлж буй эмчилгээ, сэтгэл засал, нийгэмшүүлэх ажлын ололт амжилт, туршлагаа хуваалцах, харилцан мэдээлэл солилцох;
2. Дээрх чиглэлээр хүний нөөцийг чадавхижуулах, сургаж дадлагажуулахад харилцан дэмжлэг үзүүлэх зэрэг болно;

⁸ <https://www.legalinfo.mn/law/details/12701> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017

Хавсралт мэдээлэл

График-1




График-2



График-3




График 4




График 5




График 6




График 7



График 8






График 6



Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис хэрэглэх донтой хэвтсэн эмчлүүлсэн хүмүүс, оношоор (СЭМУТ)

Он	2014	2015
Опиоидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F11	5	10
Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F12	7	8
Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F13	16	4
Кокаины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F14	0	0
Кофейн буюу бусад сэдээгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F15	1	4
Хий үзэгдлийг үүсгэгч эм бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F16	2	1
Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд F18	0	0
Олон төрлийн сэтгэц нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгүүд F19	6	12
Нийт	37	39

Хүснэгт 1

Мансууруулах болон сэтгэл идэвхит эм, бодис хэрэглэх донтой хэвтэн эмчлүүлсэн хүмүүс (СЭМҮТ)

Үзүүлэлт	2014		2015		2016		2017		2018		
	н	%	н	%	н	%	н	%	н	%	
Хүйс	эрэгтэй	20	54.1	27	69.2	26	65.0	32	60.4	40	76.9
	эмэгтэй	17	45.9	12	30.8	14	35.0	21	39.6	12	23.1
Нас	10--19	5	13.5	3	7.7	7	17.5	15	27.3	14	26.9
	20-29	11	29.7	14	35.9	15	37.5	18	32.7	20	38.5
	30-39	4	10.8	11	28.2	7	17.5	9	16.4	11	21.2
	40-49	5	13.5	5	12.8	4	10.0	4	7.3	5	9.6
	50-59	6	16.2	6	15.4	2	5.0	3	5.6	2	3.8
	60+	6	16.2	0	0	5	12.5	6	10.9	0	0.0
Давтан хэвтэн эмчлүүлэгчийн тоо			3		3		3			0.0	
Нийт	37	100	39	100	40	100	55	100	52	100	

Он	Опиоидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F11	Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F12	Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F13	Кокайны шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F14	Кофейн буюу бусад сэдээгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F15	Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд F18	Олон төрлийн сэтгэц нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгүүд F19	Нийт
2014	14	2	22	1	1	5	4	49
2015	19	3	9	0	3	5	5	44
2016	13	5	9	1	7	2	2	39
2017	10	14	9	0	5	21	3	62
2018	18	11	17	1	3	19	5	74

2016	10	6	7	0	5	1	4	7	40
2017	11	8	9	0	5	0	5	17	55
2018	12	9	4	0	1	0	7	19	52

Хүснэгт 3

Мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх эм, бодисын шалтгаант магадлагааны тоо	2014	2015	2016	2017	2018
	133	90	174	239	261

Хүснэгт 4

Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис, бүртгэгдсэн өвчлөл,

(улсын дүнгээр)